



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/183/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn Аудитын менежер: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: BoldbaatarH@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Заяа Утас: 90088028 Цахим хаяг: zayag@audit.gov.mn Гэрээт аудитор : Ц.Алтантуул Утас: 91195554 Цахим хаяг: tuul9565@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ХҮҮХЭД, ГЭР БҮЛ ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Э.ДЭЧИНСОДНОМ-Д

2025.02.25 № 317

танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас аймгийн Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аймгийн Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын газар нь 2024 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулаагүй цагийн тооцоонд үндэслэн цалинг тооцон олгосон, бэлэн мөнгөний зарлагын анхан шатны баримт, тайланг бүрдүүлэлгүйгээр бүртгэлд тусгасан, "Хүүхдийн эрхийг дээдлээ" хүүхдийн чуулган, говийн бүсэд зохион байгуулсан арга хэмжээ, "Хөөрхөн зүрхнүүдийн аян" ТББ-аар гүйцэтгүүлсэн ажил зэргийн тайлан байхгүй, гэрээг дүгнээгүй, "Эрсдэлгүй хүүхэд, ээлтэй орчин" арга хэмжээний хүрээнд тараасан өвлийн хувцасны багцын нотлох баримт дутуу, "Хөгжлийн хөтөлбөр" арга хэмжээний хүрээнд хувь хүний данс руу шилжүүлсэн мөнгө нь сургалтын тайлан бусад холбогдох анхан шатны баримтаар бүрэн нотлогдоогүй, Даян-Очир хүүхдийн зусланд төсөвт тусгагдаагүй албан хаагчдыг амруулсан, цалингийн нэмэгдлийг тушаал шийдвэргүйгээр олгосон зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.5-д "бүх орлого" 14.4.6-д "бүх зардал", гэж заасныг тус тус зөрчин, тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын газар нь тайлант онд үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 610.2 сая төгрөгийн, хүүхэд хамгаалал, урьдчилан сэргийлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 346.7 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 60.8 сая төгрөгийн, нийт 1,017.6 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанд 609.1 сая төгрөгийг, хүүхэд хамгааллын арга хэмжээнд 142.7 сая төгрөгийг, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 197.3 сая төгрөгийг тус тус зарцуулан, 68.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Завхан аймгийн Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар удирдлагын зүгээс зардлын гүйцэтгэлд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, нягтлан бодогч, эд хариуцагч, зарим мэргэжилтнүүд нь хариуцсан чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, хүүхэд хамгааллын зардлыг зарцуулахдаа холбогдох хууль журмыг мөрдөөгүй зэрэгтэй холбоотой 441.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч нь байгууллагын өдөр тутмын санхүүгийн үйл ажиллагааг удирдах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, эд хариуцагч бараа материалын тайлан болон бэлэн мөнгөний тайлангуудыг бэлтгээгүй, анхан шатны баримтын бүрдэл ханган ажиллаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>32,623,205.62</u>	<u>25,655,125.62</u>
33	АВЛАГА	20,944,580.00	8,629,000.00
335	Бусад авлага	20,944,580.00	8,629,000.00
3351	Байгууллагаас авах авлага	20,944,580.00	8,629,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	11,678,625.62	17,026,125.62
354	Хангамжийн материал	11,678,625.62	17,026,125.62
35410	Бичиг хэргийн материал	1,558,700.00	4,060,000.00
35420	Аж ахуйн материал	1,115,200.00	1,121,200.00
35430	Сэлбэг хэрэгсэл	221,000.00	221,000.00
35460	Хүнсний материал	-	15,100.00
35470	Бусад хангамжийн материал	8,783,725.62	11,608,825.62
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>418,210,776.24</u>	<u>2,049,454,246.81</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	418,210,776.24	2,049,454,246.81
392	Биет хөрөнгө	395,610,776.24	2,026,426,469.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	397,068,910.00	1,597,068,910.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(33,089,076.00)	(89,706,891.20)
39203	Тээврийн хэрэгсэл	26,149,000.00	0
	Хуримтлагдсан элэгдэл	(26,149,000.00)	0
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	147,169,634.91	371,781,996.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	(124,496,421.89)	(140,066,054.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,357,375.68	143,357,375.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,580,613.46)	(43,005,056.46)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,693,654.20	197,508,876.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,693,654.20)	(12,693,654.20)
39217	Ном	2,180,967.00	2,180,967.00
393	Биет бус хөрөнгө	22,600,000.00	23,027,777.78
39301	Програм хангамж	750,000.00	1,190,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(750,000.00)	(762,222.22)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,600,000.00	22,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>450,833,981.86</u>	<u>2,075,109,372.43</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>450,833,981.86</u>	<u>2,075,109,372.43</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	450,833,981.86	2,075,109,372.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	196,740,102.46	196,740,102.46
51101	Өмч: - төрийн	196,740,102.46	196,740,102.46
512	Хуримтлагдсан үр дүн	67,818,277.58	1,692,093,668.15
51210	Өмнөх үеийн үр дүн	67,818,277.58	67,818,277.58
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,624,275,390.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	186,275,601.82	186,275,601.82

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	450,833,981.86	2,075,109,372.43
---	--	----------------	------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	885,872,036.30	2,716,187,845.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,778,344.30	1,698,427,584.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,778,344.30	1,698,427,584.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,778,344.30	1,698,427,584.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,778,344.30	1,698,427,584.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	883,093,692.00	1,017,760,261.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,216,792.00	60,891,761.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,305,000.00	16,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,519,925.00	44,891,761.00
1330	Төсвийн захирагчдаас	751,876,900.00	956,868,500.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	751,876,900.00	956,868,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	878,105,629.58	1,091,912,454.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	878,105,629.58	1,091,912,454.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	833,416,284.98	1,000,548,671.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	332,750,915.97	381,175,275.50
210101	Үндсэн цалин	217,741,447.11	218,059,515.50
210102	Нэмэгдэл	75,931,948.83	108,726,152.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,696,154.33	39,998,077.00
210104	Урамшуулал	17,381,365.70	14,391,531.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,847,769.05	47,360,006.72
210201	Тэтгэврийн даатгал	28,445,042.38	32,689,774.66
210202	Тэтгэмжийн даатгал	3,364,923.82	3,813,516.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,691,859.15	1,916,692.18
210204	Ажилгүйдлийн даатгал	667,885.33	1,788,002.03
210205	Эрүүл мэндийн даатгал	6,678,058.37	7,152,021.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,086,461.15	88,076,221.21
210301	Гэрэл, цахилгаан	2,016,541.15	2,156,941.21
210302	Түлш, халаалт	81,911,280.00	82,578,910.00
210303	Цэвэр, бохир ус	2,158,640.00	3,340,370.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,829,348.07	4,107,271.43
210401	Бичиг хэрэг	1,387,440.00	2,037,700.00
210402	Тээвэр, шатахуун	-	300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	393,508.07	261,871.43
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	371,100.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,048,400.00	1,136,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,174,300.00	104,600.00
210604	Урсгал засвар	5,174,300.00	104,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	215,046,522.16	348,240,808.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	214,688,561.16	348,118,747.00
210807	Газрын төлбөр	122,061.00	122,061.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	132,104,268.58	131,484,488.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,258,500.00	26,936,637.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,828,391.00	26,923,738.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,017,377.58	77,624,113.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,689,344.60	91,363,783.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,997,500.00	22,775,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	21,307,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,468,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,691,844.60	68,588,483.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,691,844.60	68,588,483.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,766,406.72	1,624,275,390.57

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	883,093,692.00	1,017,760,261.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	883,093,692.00	1,017,760,261.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,216,792.00	60,891,761.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,305,000.00	16,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,519,925.00	44,891,761.00
1330	Төсвийн захирагчдаас	751,876,900.00	956,868,500.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	751,876,900.00	956,868,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	881,825,192.00	1,007,320,261.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	881,825,192.00	1,007,320,261.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	837,135,847.40	915,956,477.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	332,750,915.97	381,175,275.50
210101	Үндсэн цалин	217,741,447.11	218,059,515.50
210102	Нэмэгдэл	75,931,948.83	108,726,152.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,696,154.33	39,998,077.00
210104	Урамшуулал	17,381,365.70	14,391,531.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,847,769.05	47,360,006.72
210201	Тэтгэврийн даатгал	28,445,042.38	32,689,774.66
210202	Тэтгэмжийн даатгал	3,364,923.82	3,813,516.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,691,859.15	1,916,692.18
210204	Ажилгүйдлийн даатгал	667,885.33	1,788,002.03
210205	Эрүүл мэндийн даатгал	6,678,058.37	7,152,021.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,751,041.15	67,131,641.21
210301	Гэрэл, цахилгаан	2,016,541.15	2,156,941.21
210302	Түлш, халаалт	107,575,860.00	61,634,330.00
210303	Цэвэр, бохир ус	2,158,640.00	3,340,370.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,781,099.07	4,532,271.43
210401	Бичиг хэрэг	1,366,991.00	2,462,700.00
210402	Тээвэр, шатахуун	-	300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	393,508.07	261,871.43
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	371,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,020,600.00	1,136,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,174,300.00	115,600.00
210604	Урсгал засвар	5,174,300.00	115,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	215,628,030.16	357,963,088.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	215,270,069.16	357,667,827.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	176,600.00	173,200.00
210807	Газрын төлбөр	122,061.00	122,061.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,625,992.00	57,678,595.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,258,500.00	26,936,637.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	34,367,492.00	30,741,958.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,689,344.60	91,363,783.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,997,500.00	22,775,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	21,307,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,468,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,691,844.60	68,588,483.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,691,844.60	68,588,483.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,268,500.00	10,440,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,268,500.00	10,440,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,268,500.00	10,440,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,268,500.00	10,440,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,268,500.00	10,440,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,268,500.00)	(10,440,000.00)
---	--	-----------------------	------------------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	174,140,102.46	419,857,447.28	207,074,374.18	801,071,923.92
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	174,140,102.46	419,857,447.28	207,074,374.18	801,071,923.92
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(19,253,153.44)	(19,253,153.44)
D01	2024 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл	196,740,102.46	186,275,601.82	67,818,277.58	450,833,981.86
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	196,740,102.46	186,275,601.82	67,818,277.58	450,833,981.86
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,624,275,390.57	1,624,275,390.57
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	196,740,102.46	186,275,601.82	1,692,093,668.15	2,075,109,372.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДД	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
200	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	569,473,700.00	511,992,455.86	57,481,244.14	89.91
201	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	569,473,700.00	511,992,455.86	57,481,244.14	89.91
202	Бараа, үйлчилгээний зардал	569,473,700.00	511,992,455.86	57,481,244.14	89.91
203	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	427,312,900.00	381,175,275.50	46,137,624.50	89.20
204	Үндсэн цалин	234,439,000.00	218,059,515.50	16,379,484.50	93.01
205	Нэмэгдэл	129,637,300.00	108,726,152.00	20,911,148.00	83.87
206	Унаа, болон бусад нөхөн олговор	37,914,900.00	39,998,077.00	(2,083,177.00)	105.49
207	Урамшуулал	25,321,700.00	14,391,531.00	10,930,169.00	56.83
209	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,414,200.00	47,360,006.72	6,054,193.28	88.67
210	Тэтгэврийн даатгал	36,321,700.00	32,689,774.66	3,631,925.34	90.00
211	Тэтгэмжийн даатгал	4,273,000.00	3,813,516.81	459,483.19	89.25
212	ҮОМШӨ ний даатгал	2,136,600.00	1,916,692.18	219,907.82	89.71
213	Ажилгүйдлийн даатгал	2,136,600.00	1,788,002.03	348,597.97	83.68
214	Эрүүл мэндийн даатгал	8,546,300.00	7,152,021.04	1,394,278.96	83.69

215	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,328,400.00	67,131,641.21	4,196,758.79	94.12
216	Гэрэл цахилгаан	2,341,800.00	2,156,941.21	184,858.79	92.11
217	Түлш, халаалт	65,775,600.00	61,634,330.00	4,141,270.00	93.70
218	Цэвэр, бохир ус	3,211,000.00	3,340,370.00	(129,370.00)	104.03
220	Хангамж, бараа материалын зардал	4,702,300.00	4,532,271.43	170,028.57	96.38
221	Бичиг хэрэг	2,471,500.00	2,462,700.00	8,800.00	99.64
222	Тээвэр (шатахуун)	437,000.00	300,000.00	137,000.00	68.65
223	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	240,400.00	261,871.43	(21,471.43)	108.93
225	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	389,000.00	371,100.00	17,900.00	95.40
226	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,164,400.00	1,136,600.00	27,800.00	97.61
232	Эд хогшил худалдан авах	10,171,000.00	10,115,600.00	55,400.00	99.46
233	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
236	Урсгал засвар	171,000.00	115,600.00	55,400.00	67.60
237	Томилолт, зочны зардал	291,100.00	-	291,100.00	-
239	Дотоод албан томилолт	291,100.00	-	291,100.00	-
241	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	871,400.00	295,261.00	576,139.00	33.88
243	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	202,000.00	-	202,000.00	-
244	Даатгалын үйлчилгээ	166,700.00	-	166,700.00	-
245	Тээврийн хэрэгслийн татвар	96,900.00	-	96,900.00	-
246	Тээврийн хэрэгслийн оношилгоо	56,500.00	-	56,500.00	-
247	Мэдээллийн технологийн зардал	173,200.00	173,200.00	-	100.00
248	Газрын төлбөр	176,100.00	122,061.00	54,039.00	69.31
251	Бараа үйлчилгээний бусад зардал	1,382,400.00	1,382,400.00	-	100.00
253	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,382,400.00	1,382,400.00	-	100.00
296	ХӨТӨЛБӨР 72207	-	-	-	-
297	АРГА ХЭМЖЭЭ 80236	-	-	-	-
298	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,740,500.00	3,529,402.10	211,097.90	94.36
299	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,740,500.00	3,529,402.10	211,097.90	94.36
300	Бараа, үйлчилгээний зардал	3,740,500.00	3,529,402.10	211,097.90	94.36
339	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	3,740,500.00	3,529,402.10	211,097.90	94.36
340	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,740,500.00	3,529,402.10	211,097.90	94.36

394	ХӨТӨЛБӨР 72207	-	-	-	-
395	АРГА ХЭМЖЭЭ 80237	-	-	-	-
396	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	145,404,300.00	142,785,275.00	2,619,025.00	98.20
397	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	145,404,300.00	142,785,275.00	2,619,025.00	98.20
398	Бараа, үйлчилгээний зардал	145,404,300.00	142,785,275.00	2,619,025.00	98.20
437	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	145,404,300.00	142,785,275.00	2,619,025.00	98.20
438	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	145,404,300.00	142,785,275.00	2,619,025.00	98.20
492	ХӨТӨЛБӨР 72207	-	-	-	-
493	АРГА ХЭМЖЭЭ 80238	-	-	-	-
494	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	201,344,800.00	197,356,978.00	3,987,822.00	98.02
495	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	201,344,800.00	197,356,978.00	3,987,822.00	98.02
496	Бараа, үйлчилгээний зардал	201,344,800.00	197,356,978.00	3,987,822.00	98.02
535	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	201,344,800.00	197,356,978.00	3,987,822.00	98.02
536	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	201,344,800.00	197,356,978.00	3,987,822.00	98.02
590	ХӨТӨЛБӨР 72207	-	-	-	-
591	АРГА ХЭМЖЭЭ 80802	-	-	-	-
592	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,775,300.00	22,775,300.00	-	100.00
593	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	22,775,300.00	22,775,300.00	-	100.00
656	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,775,300.00	22,775,300.00	-	100.00
660	Бусад урсгал шилжүүлэг	22,775,300.00	22,775,300.00	-	100.00
667	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	21,307,300.00	21,307,300.00	-	100.00
668	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,468,000.00	1,468,000.00	-	100.00
688	ХӨТӨЛБӨР 72209	-	-	-	-
689	АРГА ХЭМЖЭЭ 83115	-	-	-	-
690	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	226,700.00	220,000.00	6,700.00	97.04
691	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	226,700.00	220,000.00	6,700.00	97.04
692	Бараа, үйлчилгээний зардал	226,700.00	220,000.00	6,700.00	97.04
731	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	226,700.00	220,000.00	6,700.00	97.04
732	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	226,700.00	220,000.00	6,700.00	97.04
786	ХӨТӨЛБӨР 72212	-	-	-	-
787	АРГА ХЭМЖЭЭ 83115	-	-	-	-

788	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,903,200.00	13,776,171.90	127,028.10	99.09
789	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	13,903,200.00	13,776,171.90	127,028.10	99.09
790	Бараа, үйлчилгээний зардал	13,903,200.00	13,776,171.90	127,028.10	99.09
829	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	13,903,200.00	13,776,171.90	127,028.10	99.09
830	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,903,200.00	13,776,171.90	127,028.10	99.09
916	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
919	АЖИЛЛАГСДЫН ТОО	17.00	17.00	-	100.00
920	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
921	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	-	100.00
922	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

дд	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн
4	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,736,195.00	(56,736,195.00)
5	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	56,736,195.00	(56,736,195.00)
6	Бараа, үйлчилгээний зардал	56,736,195.00	(56,736,195.00)
7	Бараа үйлчилгээний бусад зардал	56,736,195.00	(56,736,195.00)
8	Бараа үйлчилгээний бусад зардал	26,936,637.00	(26,936,637.00)
9	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,799,558.00	(29,799,558.00)
10	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	60,891,761.00	(60,891,761.00)
11	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,891,761.00	(60,891,761.00)
12	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,000,000.00	(16,000,000.00)
13	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,891,761.00	(44,891,761.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын үйл ажиллагааны чиглэл:

- Аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- Хүүхэд хамгааллын талаарх судалгаа, тайланд үндэслэн цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлийг эрэмбэлэн тодорхойлох;
- Хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, тандалт судалгаа явуулах, бүртгэх ажлыг орон нутгийн цагдаагийн байгууллага болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулах;

- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо болон хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх дундын мэдээллийн санд үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх;
- Хамтарсан багт дэмжлэг үзүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын үйлчилгээний тодорхой чиглэл буюу нийгмийн ажлын үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх, бага насны болон хохирогч хүүхэдтэй ажиллах зэрэг мэргэшсэн дэмжих багийг байгуулах;
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар нэгдсэн бүртгэл, судалгаа хөтөлж, хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн санд оруулах;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд тусламж, дэмжлэг үзүүлэх талаар хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;
- Магадлан итгэмжлэгдсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажиллах;
- Гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, хамгаалах талаар шаардлагатай зөвлөгөө, сургалт, тусламж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;
- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан сургалтад хамруулах ажлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Төрийн байгууллага, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллага, хуулийн этгээдийн ажилтан, албан хаагчийг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын зорилго:

Гэр бүлийн тулгуур үнэт зүйлд суурилсан хүүхэд, залуучуудын манлайлал-хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, бат бэх хариуцлагатай гэр бүлийг бий болгох, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, эрхийг хангах, хамгааллыг бэхжүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

- Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаарх бодлогын хэрэгжилтийг хангах, салбар дундын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах;
- Гэр бүлийн боловсрол үнэт зүйл, хариуцлагыг нэмэгдүүлж, хүчирхийлэлгүй, бат бэх, эрүүл гэр бүлийг төлөвшүүлэх;
- Хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулж, нийгэмшихүйн хөгжлийг нь дэмжих;
- Залуучуудын манлайлал, хариуцлагыг бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, дэмжих бүлэг, сонирхлын зөв нэгдлийг дэмжиж, амьдрах ухааны боловсролыг олгох;
- Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөгөө, хяналт-шинжилгээ, үнэлгээ, судалгаа, нотолгоонд суурилсан төлөвлөлтийг төлөвшүүлж, албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, байгууллагын үйлчилгээний шинэ соёлыг нэмэгдүүлэх;

Үйл ажиллагааны баримтлах чиглэл: “Хэрэгцээнд суурилсан шинжлэх ухааны эш үндэс, тооцоо судалгаатай бодлогын төлөвлөлт, үр дүнтэй хэрэгжилт, хариуцлагатай тайлагналтын хэрэглээг бий болгох, хүндээ хүрсэн мэргэжлийн үйлчилгээг нэвтрүүлнэ”

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Гэр бүлийн тухай хууль
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
3. Шүүхийн шинжилгээний тухай хууль
4. Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль
5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль
7. Хүүхдийн эрхийн тухай хууль
8. Хүүхэд хамгааллын тухай хууль
9. Иргэний улсын бүртгэлийн тухай хууль
10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
11. Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль
12. Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтыг зохион байгуулах журам, Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтын маягтыг баталж хэрэгжүүлэх тухай
13. Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам
14. Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам, Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээний маягт, Хүүхэд хамгааллын үйлчилгээний багц маягтыг баталж хэрэгжүүлэх тухай
15. Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн, хариу үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүдэд нэмэгдэл урамшуулал олгох тухай
16. Нэг цэгин үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам.
17. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах журам
18. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрэм батлах тухай
19. Монголын нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг баталж хэрэгжүүлэх тухай
20. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналт хангалттай хэрэгждэггүй сул байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 1,624,275.39 мянган төгрөгөөр буюу 460.2 хувиар өссөн нь өндөр өртөг бүхий барилга хүлээн авсантай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	20,944.58	8,629.00	-12,315.58
Бараа материал	11,678.63	17,026.13	5,347.50)
Үндсэн хөрөнгө	418,210.78	2,049,454.25	1,631,243.47
Нийт хөрөнгө	450,833.98	2,075,109.37	1,624,275.39
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	450,833.98	2,075,109.37	1,624,275.39
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	450,833.98	2,075,109.37	1,624,275.39

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Авлагын эхний үлдэгдэл 20,944.5 мянган төгрөг байснаас тайлант онд 12,315.5 төгрөгийн авлагыг барагдуулж, эцсийн үлдэгдэл 8,629.0 мянган төгрөг болсон байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 5,347.5 мянган төгрөгөөр өссөн нь 127,157.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 121,809.5 мянган төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой байна. Бараа материалаарх хөрөнгийн худалдан авалтын 82 хувийг хүүхэд хамгааллын арга хэмжээнд зарцуулан, хүүхдийн шуурхай багц, хүүхдийн өвөл, хавар, намрын хувцас, хичээлийн хэрэглэл эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 1,624,275.39 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Мичид кино театрын барилгыг 1,200,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий кино театрын барилгыг үнэ төлбөргүйгээр орон нутгийн удирдлагын шийдвэрээр шилжүүлэн өгсөн, 498,427.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан, 10,440.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 26,149.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг шийдвэрийн дагуу данснаас хассан зэрэгтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 1,624,275.39 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 956,868.5 мянган төгрөгийн санхүүжилт авахаар, нийт зарлагыг 956,868.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 956,868,5 мянган төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд төсвийн нийт зардлын гүйцэтгэл 892,435.5 мянган төгрөг буюу 93.1 хувьтай байгаа нь санхүүжилтээс 64,432.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
72207	Хүүхдийн хөгжил хамгаалал				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	569,473.70	511,992.46	57,481.24	89.90%
80236	Эрсдэлийн болон НБҮ	3,740.50	3,529.40	211.10	94.30%
80802	Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ	22,775.30	22,775.30	0	100.00%
80237	Хүүхэд хамгаалал	145,404.30	142,785.28	2,619.03	98.10%
80238	Хүүхэд хөгжил	201,344.80	197,356.98	3,987.82	98.01%
72209	Хүүхэд хөгжил хамгаалал				0.00%
83115	Гэр бүлийн хөгжил хамгаалал	226.70	220.00	6.70	89.90%
72212	Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр				89.90%
83115	Нийгмийн бүлэг	13,903.20	13,776.17	127.03	89.90%
	НИЙТ	956,869.0	892,436.0	64,432.92	93.10%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 60,891.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснээс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж 4,155.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3.1 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Хүүхэд хамгааллын багц нийлүүлэх	364,619.5	357,963.09
2	Шууд гэрээ байгуулах	Гэрэл цахилгаан	2,431.8	2,156.9
3	Шууд гэрээ байгуулах	Түлш халаалт	65,775.6	61,634.3
4	Шууд гэрээ байгуулах	Цэвэр бохир ус	3,211.0	3,340.3
5	Шууд худалдан авалтаар	Хөрөнгө бэлтгэх	10,440.00	10,440.00
ДҮН			446,477.9	435,534.6

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүлд аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Заяа, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн

Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр 03 дугаартай албан тоотой ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,091,912.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 16,378.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын шилэн дансны мэдээллийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн байна* гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 753,328.3 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрснээс аудитын явцад 311,903.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,010.6 мянган төлбөрийн акт тогтоож, 434,414.40 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайланд авлагыг 8,576.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн, мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан хөрөнгийн дүнг 303,327.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлж бичсэн алдааг тус тус залруулсан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.1 Төлбөрийн акт

Анхан шатны баримтгүйгээр 250.0 мянган төгрөгийн зардал гаргасан, Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд сургалт явуулахаар 4,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч тухайн сургалтыг зохион байгуулаагүй, "Эрсдэлгүй хүүхэд ээлтэй орчин" арга хэмжээний хүрээнд зарцуулсан зардлаас 2,760.6 мянган төгрөгийн өртөг бүхий хувцас дутагдуулсан зэрэгтэй холбоотой зөрчлүүдийг илрүүлэн, 7,010.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Ажилтнуудад олгосон 381,175.2 мянган төгрөгийн цалинг цагийн тооцоо болон гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, тушаал шийдвэргүйгээр 14,604.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл нэр бүхий ажилтнуудад олгосон, "Хүүхдийн эрхийг дээдлэе" аймгийн хүүхдийн чуулганд зарцуулсан 12,886.0 мянган төгрөгийн, Говийн бүсийн арга хэмжээнд зарцуулсан 5,092.0 мянган төгрөгийн зардлууд ажлын тайлангүй, "Хөөрхөн зүрхнүүдийн аян" ТББ-тай хамтран явуулсан 13,800.0 мянган төгрөгийн арга хэмжээний ажлын тайлан болон гэрээ дүгнэсэн акт байхгүй, "Даян" хүүхдийн зусланд амруулахаар тооцсон хүүхдүүдийн оронд ажилтан, албан хаагчдыг амруулан 1,925.0 мянган төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан, 4,932.0 мянган төгрөгийг бэлнээр зарцуулахдаа гүйцэтгэсэн ажлын тайлан болон анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй зэрэг зөрчлүүдийг илрүүлэн албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж хүргүүлээгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

3 төрлийн арга хэмжээний ажлын тайлан үр дүн байхгүй	1	31,778.1		1	31,778.1														
Цагийн тооцоо үндэслэх баримтгүй сарын цалин тооцон олгодог	1	381,175.2		1	381,175.2														
Тушаал шийдвэргүй ур чадварын нэмэгдэл тооцон олгосон	1	14,604.0		1	14,604.0														
Бэлэн мөнгөний тайлан бэлтгэн гаргаагүй	1	4,932.0		1	4,932.0														
Даян-Очир зусланд хүүхдийн тоонд оруулж албан хаагч нарыг явуулсан.	1	1,925.0		1	1,925.0														

Анхан шатны баримтгүй мөнгө шилжүүлсэн	1	250.0	1	250.0															
Сургалтын төлбөр шилжүүлсэн боловч сургалт хийгээгүй	1	4,000.0	1	4,000.0															
Хүүхдийн хувцас авч тараасан боловч тараасан жагсаалтгүй баримт байхгүй	1	2,760.0	1	2,760.0															
Дүн	5	441,424. ⁴	3	7,010.0	5	434,414.4													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/										
	Нийт зөрчил					Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
Дүн											
Нийт дүн											

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д. БАТ-УНДРАА ОГНОО: 2025-02-25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:



Х. БОЛДБААТАР ОГНОО: 2025-02-25

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Г. ЗАЯА ОГНОО: 2025-02-25

БОЛОВСРУУЛСАН:

СҮЛД АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР



Ц. АЛТАНТУУЛ ОГНОО: 2025-02-22

